



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Инфляцын тайлан

2023 | 12-р сар



АГУУЛГА

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН СТРАТЕГИ.....	3
МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР	4
ТОЙМ.....	5
1. ИНФЛЯЦ	7
1.1. Инфляцын цаашдын төлөв	7
1.2. Инфляцын гүйцэтгэл.....	9
1.3. Төсөөллийн зөрүү.....	10
2. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ	10
2.1. Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв	10
2.2. Эдийн засгийн өсөлтийн гүйцэтгэл.....	13
3. ДОТООД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН.....	16
3.1. Хөдөлмөрийн зах зээл.....	16
3.2. Мөнгө, санхүүгийн зах зээл	18
3.2.1. Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд.....	18
3.2.2. Хүү.....	20
3.2.3. Валютын ханш.....	21
3.2.4. Хөрөнгийн зах зээл	22
3.3. Нэгдсэн төсөв болон Засгийн газрын өр.....	24
4. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН	26
4.1. Эдийн засгийн гадаад орчны төсөөлөл	26
4.2. Экспортын үнийн төлөв.....	27
4.3. Төлбөрийн тэнцэл	28

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН СТРАТЕГИ

Төв банкны тухай хуульд **Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангах** гэж тодорхойлсон байдаг. Энэ зорилтын хүрээнд Монголбанк хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах бодлогыг “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл”-д тусган хэрэгжүүлж байна. Инфляцыг нам түвшинд тогтворжуулснаар иргэдийн бодит орлого, хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалж, банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдал хангагдах нөхцөлийг бүрдүүлэх төдийгүй хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжинэ. Монголбанк **инфляцыг дунд хугацаанд жилийн 6 хувь орчимд, +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулахыг** зорьж байна.

Монголбанкнаас мөнгөний бодлогын хүрээнд бодлогын хүүг өөрчилснөөр санхүүгийн зах зээлийн хүү, мөнгө, зээлийн эрэлт, нийлүүлэлтэд, улмаар үйлдвэрлэлийн хэмжээ, хөрөнгийн үнэ, хүлээлт, валютын ханш, дотоод эрэлтэд нөлөөлөх замаар инфляцын түвшин, түүний хүлээлтийг тогтворжуулахыг зорьдог. Түүнчлэн, 2018 оноос эхлэн макро зохистой бодлогын хүрээнд системийн хэмжээнд мөрдүүлэхүйц банкны зохистой харьцааны хэрэгслүүдээр дамжуулан банкны зээлийн хэт өсөлт, үүний аль нэг салбар, бүтээгдэхүүн эсвэл гадаад валютад хэт төвлөрсөн байдлыг оновчтой удирдах зэрэгт чиглэсэн арга хэмжээг мөнгөний бодлогын арга хэрэгслүүдтэй хослуулан хэрэглэх стратегийг баримталж байна.

Монголбанк мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулахын тулд олон нийттэй харилцах харилцааны нээлттэй байдалд ач холбогдол өгч байна. Иймд Монголбанк макро үзүүлэлтүүдийн гүйцэтгэл, инфляц, эдийн засгийн ойрын төлөв байдал, түүнд нөлөөлж буй гадаад эдийн засаг, санхүүгийн салбар, нийт эрэлт, нийлүүлэлт, ажил эрхлэлт, үнэ, өртгийн хүчин зүйлс зэргийг Инфляцын тайланд танилцуулж, улирал тутам олон нийтэд мэдээлж байна. Төв банкны зорилтод нийцтэй, инфляцын төсөөлөлд үндэслэн авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын арга хэмжээ, үр дүнг олон нийтэд нээлттэй танилцуулснаар бодлогын ил тод байдлыг хангах, Монголбанканд итгэх итгэлийг дээшлүүлэх замаар зах зээлд оролцогчдод ирээдүйн талаар мэдээлэл өгөх, хүлээлтийг удирдах ач холбогдолтой.

Монголбанкны мөнгөний бодлогын үйл ажиллагааны зорилт нь банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү байдаг. Энэ зорилтын хүрээнд Монголбанкнаас нээлттэй захын үйл ажиллагаа, хүүгийн нэгдсэн бодлого, репо санхүүжилт болон бусад мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийг ашиглаж байна. Мөнгөний бодлогын шилжих механизм ёсоор банк хоорондын захын хүүгийн өөрчлөлт нь хадгаламж, зээлийн хүү болон бусад хөрөнгийн үнэд нөлөөлснөөр инфляц болон тэдгээрийн ирээдүйн төлөвийн талаарх хүлээлтэд нөлөөлдөг. Ингэхдээ бодлогын хэрэгсэл нь эцсийн зорилт болох эдийн засгийн идэвхжил, инфляцад тодорхой хугацааны хоцролттой нөлөөлдөг.

Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны арилжаа нь банк хоорондын захын богино хугацаатай хүү, банкуудын эх үүсвэрийн хэлбэлзлийг удирдах замаар мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл болж байна. Түүнчлэн бодлогын хүүгийн коридор системтэй уялдуулан мөнгөний бодлогын бусад хэрэгслүүдийн хүү тодорхойлогдож байна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2023 оны 12-р сарын 13, 14-ний өдрийн ээлжит хурлаар бодлогын хүүг 13 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа.

Мөнгөний бодлогын 2023 оны 12-р сарын 14-ний өдрийн мэдэгдлийн дэлгэрэнгүйг [ЭНДЭЭС](#) уншина уу.

Инфляцын тайланд орсон тоон өгөгдөл, зураг, хүснэгтийг [дараах](#) линкээр орж татан авах боломжтой.

ТОЙМ

Инфляц энэ онд өмнөх төсөөлөлтэй нийцтэйгээр алгуур буурах бол ирэх онд эрэлтийн нөлөөгөөр өмнөх төсөөллөөс нэмэгдэхээр байна. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт хүлээж байснаас өндөр байж, эдийн засгийн идэвхжлийг дэмжлээ. Гадаад эдийн засгийн орчинд эрсдэл, тодорхой бус байдал төдийлөн буураагүйн дээр манай улсын худалдааны гол түнш БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удаашрах хүлээлттэй байгаа нь экспортын түүхий эдийн эрэлт болон үнэд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Монголбанкны Мөнгөний бодлогын хороо эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал, гадаад орчны төлөв, эрсдэлийг харгалзан 2023 оны 12 дугаар сард бодлогын хүүг 13 хувьд хэвээр хадгалах шийдвэрийг гаргалаа. Энэхүү бодлогын шийдвэр гаргахад ашигласан суурь мэдээллийг Инфляцын тайланд тайлбарлаж, хүргэдэг.

Ирэх оны инфляцын төсөөлөл өмнөх төсөөллөөс нэмэгдэхээр байна. Инфляц өмнөх төсөөлөлтэй нийцтэйгээр алгуур буурч, энэ оны 11 дүгээр сард улсын хэмжээнд 8.6 хувь, Улаанбаатар хотод 9.4 хувьд хүрлээ. Төгрөгийн ханш тогтворжин, тээврийн зардал буурч, гадаад үнийн дарамт багассан нь инфляц буурахад голлон нөлөөлөв. Импортын бараа, бүтээгдэхүүний инфляц 2021 оны 6 сараас тасралтгүй саарч, тайлант сард 6.4 хувьд хүрч буурлаа. Инфляц энэ онд 9.2 хувь орчимд байх бол ирэх онд төсвийн зардлын өсөлт, тэр дундаа цалин, тэтгэврийн хэмжээ үргэлжлэн нэмэгдэж, эрэлтийн шалтгаантай инфляцын дарамтыг нэмэгдүүлэхээр байна. Улмаар инфляцын буурах хурд удааширч, Төв банкны зорилтын дээд интервалд ирж тогтворжих хугацаа 2025 оны эхэн болж хойшилж байна.

Уул уурхайн үйлдвэрлэл эрчимжин, дотоод эдийн засгийн идэвхжил хүлээлтээс давлаа. Нүүрсний экспорт түүхэн дээд хэмжээнд хүрч, уул уурхайн үйлдвэрлэл энэ оны эхний 3-н улиралд 33 хувиар өслөө. Үүнийг дагаад ачаа тээврийн орлого эрчимтэй нэмэгдсэнээс гадна өрхийн хэрэглээ үргэлжлэн сэргэж, худалдаа, үйлчилгээ, бүтээгдэхүүний цэвэр татварыг дэмжлээ. Эрэлт талаас уул уурхайн бүтээгдэхүүний экспорт, эцсийн хэрэглээ өсөлтийг голлон тэтгэв. Хөдөлмөрийн захын хувьд ажилгүйдлийн түвшин түүхэн доод түвшинд хүрсэн бол ажил эрхлэлт, тэр дундаа уул уурхай, барилга, худалдаа тээврийн салбарт ажиллагсадын тоо тайлант улиралд өмнөх оны мөн үеэс нэмэгдлээ.

Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв өмнөх төсөөллөөс сайжирлаа. Эхний 3 улирлын гүйцэтгэл өндөр гарсан болон нүүрсний экспорт нэмэгдэхээр байгааг харгалзан энэ оны эдийн засгийн өсөлтийн төсөөллийг өмнөхөөс сайжрууллаа. Цаашид уул уурхайн үйлдвэрлэл нэмэгдэх, төсвийн төлөв сулрах зэрэг нь дотоод эдийн засгийн идэвхжлийг тэтгэж, ирэх жилд эдийн засгийн өсөлт 6 орчим хувьд хадгалагдах төлөвтэй байна. Харин 2025 оноос Оюу толгойн үйлдвэрлэл эрчимжин, уул уурхайн салбарын өсөлт нэмэгдэх хэдий ч хөрөнгө оруулалт буурах, төсвийн төлөв чангарах нь уул уурхайн бус салбарт сөргөөр нөлөөлж, эдийн засгийн өсөлт саарах хүлээлттэй байна.

Гадаад эдийн засгийн орчны төлөв үргэлжлэн муудлаа. Дэлхийн эдийн засгийн өсөлт саарах, БНХАУ-ын өсөлтийн төлөв удаашрах хандлага ирэх жилүүдэд үргэлжлэхээр байна. Түүнчлэн, БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналтаас шалтгаалан олон улсын зах зээлд металлын үнэ буурах эрсдэл нэмэгдлээ. ХНБ, Европын төв банк зэрэг дэлхийн томоохон төв банкууд энэ оны 10-р сарын хурлаар бодлогын хүүгээ хэвээр хадгалах шийдвэрийг гаргав.

Дэлхийн ихэнх оронд инфляц саарах хандлага үргэлжилж байгаа ч төв банкуудын зорилтот түвшинд хүрч буураагүй байна.

Экспортын огцом өсөлтийг даган төлбөрийн тэнцэл энэ оны эхний 9 сард 791 сая ам.долларын ашигтай гарлаа. Сүүлийн 16 жилийн турш алдагдалтай байсан урсгал данс эхний 9 сард 468 сая ам.долларын ашигтай гарахад нүүрсний экспорт эрчимжсэн, хэрэглээний бүтээгдэхүүний импортын өсөлт саарсан нь гол нөлөөг үзүүлэв. Санхүүгийн дансны хувьд Оюу толгойн далд уурхайн санхүүжилт санхүүгийн дансны орох урсгалыг голлон бүрдүүлсэн хэвээр байна.

Мөнгөний нийлүүлэлт болон зээлийн өсөлт эрчимжих хандлага үргэлжилж байна. М2 мөнгөний өсөлт энэ оны 10 дугаар сард 23.5 хувьд хүрч нэмэгдэхэд төлбөрийн тэнцэл ашигтай гарч, гадаад цэвэр актив нэмэгдсэн, зээлийн өсөлт сэргэж байгаа зэрэг нь нөлөөлөв. Хэрэглээний зориулалттай зээлийн өсөлт өнгөрсөн оны сүүлийн хагасаас эрчимжин, зээлийн өсөлтийг голлон бүрдүүлж байгаа ч бизнесийн зээлийн өсөлт бага хэвээр байна. Бодлогын хүү энэ оны туршид 13 хувьд хадгалагдаж, банкуудын шинээр олгосон болон шинээр татсан хадгаламжийн хүү өөрчлөлт багатай байлаа.

Тээврийн зардал, гадаад үнэ, ханш зэрэг гадаад шалтгаантай үнийн дарамт багасаж байгаагийн зэрэгцээ инфляцыг зорилтот түвшинд тогтворжуулахад чиглэсэн бодлогын арга хэмжээ үр дүнгээ өгснөөр инфляц алгуур буурч байна. Гэхдээ инфляцын цаашдын төлөв төсвийн зардал, тэр дундаа цалин, тэтгэврийн өсөлтийн нөлөө, цаг агаарын нөхцөл байдал, түлш, шатахууны ханган нийлүүлэлт зэрэг хүчин зүйлсээс ихээхэн хамаарахаар байна. Цаашид эдийн засгийн сэргэлт, инфляцын өрнөл, нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлс, олон улсад бий болж буй өөрчлөлтүүдтэй уялдуулан инфляцыг дунд хугацаанд тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогын дараагийн алхмуудыг тухай бүр авч хэрэгжүүлнэ.

1. ИНФЛЯЦ

1.1. Инфляцын цаашдын төлөв


Төсөөлөлд ашигласан гол таамаглалт нөхцөлүүд:

- Бодлогын хүүг 2023 оны 4 дүгээр улирал, 2024 оны 1 дүгээр улиралд 13 хувьд хэвээр хадгалах;
- Нийлүүлэлтийн болон хилийн хязгаарлалт байхгүй.
- АИ-92 шатахуун авах гэрээний үнэ өөрчлөгдөхгүй.
- Төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнэ өөрчлөгдөхгүй.
- Цаг агаарын нөхцөл байдал хэвийн байна гэсэн таамаглалт нөхцөл дээр үндэслэн суурь төсөөллийг боловсрууллаа.

Инфляц энэ онд өмнөх төсөөлөлтэй нийцтэйгээр алгуур буурах хүлээлт хэвээр байна. Харин ирэх оны инфляцын төсөөлөл эрэлтийн шалтгаанаар өмнөх төсөөллөөс нэмэгдлээ. 2024 оны батлагдсан төсвийн мэдээллээр ирэх онд төсвийн зардал нэмэгдэх, тэр дундаа өндөр настны тэтгэвэр, төрийн албан хаагчдын цалин үргэлжлэн өсөхөөр байгаа нь дотоод эрэлтийг урамшуулж, инфляцын дарамтыг нэмэгдүүлнэ гэж үзлээ. Мөн 3 дугаар улиралд боловсролын үйлчилгээний үнэ сүүлийн 10 жилийн дунджаас 2 дахин өндрөөр өссөн нь ирэх улирлуудад хүнсний бус инфляц өмнөх төсөөллөөс нэмэгдэх нэг хүчин зүйл болж байна. Түүнчлэн, ирэх онд гадаад үнүүд эргэн өсөхөөр хүлээгдэж байгаа нь инфляцын төсөөлөл нэмэгдэхэд нөлөөлнө.

Инфляц 2023-2025 оны эцэст харгалзан 9.2 хувь, 8.7 хувь, 7.7 хувь байх төсөөлөлтэй байна.

Зураг 1.1 Инфляцын өмнөх болон одоогийн төсөөлөл



Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш алгуур чангарч, тээврийн зардлууд бууран, гадаад шалтгаантай үнийн дарамт багассанаар инфляц оны сүүлийн саруудад алгуур буурахаар байна. Хүнсний инфляцын хувьд гурил, сүү, сүүн бүтээгдэхүүн зэрэг дотоодын хүнсний үнэ 2022 оны сүүлийн улиралд эрчтэй өссөн суурь үеийн нөлөөгөөр буурахаар байна. Төгрөгийн ханш тогтворжин импортын барааны инфляц буурах, улмаар үйлдвэрлэлийн орцын зардлаар дамжин дотоодын бараа, үйлчилгээний инфляц саарах хандлага энэ онд үргэлжлэхээр байна.

Ирэх онд гадаад үнэ өсөх, төсвийн төлөв сулрах зэргээс шалтгаалан инфляцын буурах хурд удаашрах төсөөлөлтэй байна. Нийлүүлэлтийн аливаа төрлийн шок үүсэхгүй, цаг агаарын нөхцөл байдал хэвийн гэж үзвэл хүнсний инфляц энэ онд өндөр өсөлттэй байсан суурь үеийн нөлөөгөөр буурахаар байна. Харин уул уурхайн бус салбарын идэвхжил нэмэгдэх, төсвийн зардлууд тэлэх, төгрөгийн ханш сулрах нөлөөгөөр хүнсний бус инфляц нэмэгдэхээр байна. Шатахууны үнийн

хувьд дэлхийн зах зээлд дээрх газрын тосны үнэ буурах, АИ-92 шатахууныг хөнгөлөлттэй үнээр худалдан авах гэрээ хэвээр байна гэж үзсэнээр шатахууны инфляц ирэх онд нам түвшинд хадгалагдахаар байна.

2025 онд уул уурхайн бус салбарын идэвхжил суларч дотоод эрэлт муудах, дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ болон гадаад инфляц буурах зэргээс шалтгаалан инфляц саарч, Төв банкны зорилтын дээд интервалын орчимд хэлбэлзэх хүлээлттэй байна.

Хүснэгт 1.1 Инфляцын төсөөлөл

	2023.10	2023*	2024*	2025*
		<i>төсөөлөл</i>		
Инфляц ¹	9.4	9.2 [8.7-9.7] ²	8.7 [6.8-10.7]	7.7 [6.1-9.2]

Эх сурвалж: Монголбанк

Инфляцын төсөөллийг өөрчилж болзошгүй тодорхой бус байдал:

Эрсдэл, тодорхой бус байдал	Магадлал	Нөлөө
Төсвийн тодотголоор цалин, тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ энэ онд нэмэгдсэн, ирэх онд дахин өсөхөөр байгаа нь хувийн секторын цалин өсөх дарамтыг нэмэгдүүлэхээр байна. Дундаж цалин суурь төсөөлөлд авч үзсэнээс өндөр өсөх нөхцөлд инфляц төсөөллөөс давж нэмэгдэх эрсдэлтэй.	Өндөр	Дунд (Өсгөх)
Төсвийн зардал ирэх онд нэмэгдэх, ялангуяа урсгал зардлууд огцом тэлэхээр хүлээгдэж байгаа нь хэрэглээний бараа, бүтээгдэхүүний импортыг урамшуулах, ханш сулрах дарамтыг нэмэгдүүлэх, цаашлаад дотоодын барааны үнийг хүлээлтээс өндөр өсгөж, инфляцыг эрчимжүүлэх эрсдэлтэй.	Дунд	Дунд (Өсгөх)

¹ ХҮИ-ээр хэмжигдэх инфляц, 4 дүгээр улирлын дундаж

² 30 хувийн магадлалтай итгэх интервал

Эрсдэл, тодорхой бус байдал	Магадлал	Нөлөө
Энэ жил дийлэнх нутгаар эрт цас их орсноос шалтгаалж өвөлжилт, хаваржилт ихэнх нутгуудад хүндрэх, зудад нэрвэгдэх эрсдэл үүсэж болзошгүй байна. Энэ нөхцөлд малын зүй бус хорогдол нэмэгдэх, нийлүүлэлтийн шалтгаанаар махны үнэ өсөж, инфляцыг нэмэгдүүлэх эрсдэлтэй.	Өндөр	Өндөр (Өсгөх)
Түлш, шатахууны нийлүүлэлт удаашрах, тасалдах тохиолдолд бараа, бүтээгдэхүүний ханган нийлүүлэлт саарч, нийлүүлэлтийн шалтгаанаар үнэ өсөх эрсдэл үүсэж болзошгүй.	Дунд	Дунд

Инфляцын богино хугацааны хүлээлт өмнөх улирлаас буурлаа³.

Инфляцын хүлээлтийн судалгаагаар иргэдийн дунд инфляц өснө гэсэн хүлээлт буурч, харин ирэх 3 сард инфляц хэвэндээ байна эсвэл буурна гэсэн хүлээлт давамгайлж байна.

Зураг 1.2 Үнийн өсөлтийн талаарх хандлага (чиглэлийн индекс, 3 сар)



Эх сурвалж: Монголбанк

Тодруулбал, өмнөх улирлын түүвэр судалгаанд оролцогчдын 41 хувь нь ирэх улиралд инфляц өснө, 24 хувь нь буурна гэж хүлээж байсан бол энэ улиралд иргэдийн 24

³ Монголбанкны Судалгаа статистикийн газраас улирал бүр боловсруулдаг “Инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа”-ны тайланд үндэслэв.


хувь нь инфляц өснө, 43 хувь нь инфляц хэвэндээ байна, 33 хувь нь инфляц буурна гэсэн хүлээлттэй болсон байна. Сүүлийн саруудад инфляц алгуур буурч байгаа нь инфляцын хүлээлт тогтворжиж, үнийн өсөлтийн талаарх хандлага өөрчлөгдөхөд нөлөөлж байна.

1.2. Инфляцын гүйцэтгэл

Монголбанк хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн инфляцыг дунд хугацаанд жилийн 6 хувийн орчимд, +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулах зорилттой ажиллаж байна.

Инфляц III улиралд улсын хэмжээнд 9.8 хувь, Улаанбаатар хотод 9.9 хувьд хүрч өмнөх улирлаас 1.3 болон 0.8 нэгж хувиар буурсан байна. Үүнд, нийт импортын барааны инфляцад үзүүлэх нөлөө 1.0 нэгж хувиар, дотоодын хүнс 0.3 нэгж хувиар буурсан нь нөлөөллөө.

Зураг 1.3 Инфляц



Эх сурвалж: УСХ

Инфляц 2023 оны 11 дүгээр сард улсын хэмжээнд 8.6 хувь, Улаанбаатар хотод 9.4 хувьд хүрч алгуур буурах хандлага үргэлжилж байна (Зураг 1.3).

Зураг 1.4, 1.5-т үзүүлсэнчлэн улсын инфляцын хөдөлгөөнд голлон нөлөөлж буй бүлгүүдийг дэлгэрүүлж тайлбарлавал:

Дотоодын хүнсний үнийн өсөлт сүүлийн саруудад буурч, 11-р сарын байдлаар 16.3 хүрчээ. Ийнхүү жилийн өсөлт сүүлийн 10 сарын хамгийн бага түвшинд хүрсэн хэдий ч инфляцын 40 орчим хувийг буюу 3.3 нэгж хувийг бүрдүүлж байна.

Махнаас бусад хүнсний инфляц сүүлийн 2 жил гаруй хугацаанд 20-оос дээш хувийн өсөлтийг хадгалсан бол 11-р сард 16.2 хувь болж буурчээ. Ийнхүү буурахад хүнсний ногоо, гурил, гурилан бүтээгдэхүүний үнийн суурь үе нөлөөллөө.


Зураг 1.4 Инфляц, түүнд нөлөөлөгч гол хүчин зүйлүүд



Эх сурвалж: УСХ, Монголбанк

Үйлчилгээний бүлгийн инфляцад эзлэх хувь өндөр хэвээр хадгалагдлаа. 2023 оны 8 дугаар сард сургалтын төлбөр олон жилийн дунджаас 2 дахин их буюу 22 хувиар өссөн нь үйлчилгээний инфляцыг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болсон байна. Харин бусад үйлчилгээний инфляц 5 дугаар сараас хойш тогтвортой байлаа.

Импортын нийт бараа, бүтээгдэхүүний инфляц 2021 оны 6-р сараас тасралтгүй саарч, тайлант сард 6.4 хувь болж буурчээ. Ханш, тээвэр, гадаад үнэ зэрэг нь тогтвортой байгаа нь импортын барааны үнэд нөлөөлж байна (Зураг 1.4)

Зураг 1.5 Улаанбаатар хотын жилийн инфляц бүрэлдэхүүнээр⁴

Эх сурвалж: УСХ, Монголбанк

1.3. Төсөөллийн зөрүү

Энэ оны III улирлын дундаж инфляц төсөөллийн орчимд хүрч буурав. Тодруулбал, хүнсний бүлгийн инфляц ялимгүй бага, харин хүнсний бус бүлгийн үнэ төсөөллөөс өндөр гарахад боловсролын үйлчилгээний үнэ хүлээлтээс эрчтэй өссөн нь нөлөөлөв.

2. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

2.1. Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв

Төсөөлөлд ашигласан гол таамаглалт нөхцөлүүд:

- Бодлогын хүүг 2023 оны 4 дүгээр улирал, 2024 оны 1 дүгээр улиралд 13 хувьд хэвээр хадгалах;
- Нүүрсний экспортын биет хэмжээ 2023 онд 13 сая.тн, 2024 онд 10 сая.тн, 2025 онд 5 сая.тн-оор тус тус өмнөх төсөөллөөс нэмэгдэх;
- Гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийт орох урсгал 2023 онд 250 сая орчим ам.доллаар өмнөх оноос буурах, 2024 онд 200 орчим сая ам.доллаар өмнөх оноос өсөх, 2025

онд 800 гаруй сая ам.доллаар өмнөх оноос буурах;

- "2024 онд Хөөт-Бичигт чиглэлийн 236 км төмөр зам баригдах"-аас өөр мега төсөл хэрэгжихгүй;
- Цаг агаарын нөхцөл байдал хэвийн, нийлүүлэлтийн доголдол болон хилийн аливаа хязгаарлалт байхгүй.

Эдийн засгийн өсөлт 2023 онд 6.9 хувь, 2024 онд 6.2 хувь, 2025 онд 5.3 хувьд хүрэх тооцоололтой байна (Хүснэгт 2.1). Эдийн засгийн өсөлтийн төсөөллийг нийлүүлэлт болон эрэлт талаас тайлбарлав.

Хүснэгт 2.1 Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл⁵

	2022	2023*	2024*	2025*
		Төсөөлөл		
ДНБ-ий өсөлт	5.0	6.9 [5.2-8.0]	6.2 [3.8-8.6]	5.3 [2.2-7.9]
Уул уурхай	-15.3	28.7 [27.2-30.2]	10.0 [7.5-12.5]	19.5 [16.3-22.8]
Уул уурхайн бус	8.2	4.2 [2.7-5.7]	5.6 [3.1-8.1]	3.0 [0.6-6.4]

Эх сурвалж: Монголбанк

Нийт нийлүүлэлт

Нүүрсний экспорт нэмэгдэх, эдийн засгийн өсөлтийн гүйцэтгэл өндөр гарсантай уялдуулан 2023 оны эдийн засгийн өсөлтийн төсөөллийг өмнөх төсөөллөөс нэмэгдүүлжээ (Зураг 2.1). Ирэх жил уул уурхайн салбарын идэвхжил нэмэгдэх, түүний эерэг дам нөлөө болон төсвийн тэлэлтээр дамжин эдийн засгийн өсөлт өмнөх төсөөллөөс нэмэгдэхээр байна.

Уул уурхай: Нүүрсний экспорт энэ онд түүхэн дээд түвшинд хүрч, олборлолт нэмэгдэхээс гадна зэсийн баяжмал, газрын тосны экспорт өмнөх оноос сайжирч, уул уурхайн салбар энэ онд 28.7 хувиар өсөхөөр байна. Ирэх онд зэсийн баяжмал болон баяжмал дахь зэс, алтны агууламж энэ оноос


⁴ Үйлчилгээ, төрийн зохицуулалтай үйлчилгээний бүлгийг нэгтгэж "Үйлчилгээ", хатуу түлш, бусад дотоодын бараа бүлгийг нэгтгэж "Дотоодын бараа", мах,

махнаас бусад дотоодын хүнсний бүлгийг нэгтгэж "Дотоодын хүнс"-ий бүлэг болгов.

⁵ 30 хувийн магадлалтай итгэх интервал

нэмэгдэх, төмрийн хүдэр, газрын тосны олборлолт сайжирч, уул уурхайн салбарын өсөлтийг тэтгэхээр байна. Зэсийн баяжмалын олборлолт 2025 оноос эрчимжин уул уурхайн салбарын өсөлтийг тэтгэх хүлээлт хэвээр байна.

Зураг 2.1 4 улирлын нийлбэр ДНБ-ий жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Уул уурхайн бус салбар: Уул уурхайн бус салбар энэ онд 4.2 хувиар өсөх хүлээлттэй бөгөөд үүнд тээвэр, худалдааны салбарын өсөлт голлох нөлөөг үзүүлэх төлөвтэй. Тодруулбал, нүүрсний экспорт нэмэгдсэнээр тээврийн салбарын үйлдвэрлэл эрчимжих бол өрхийн орлого тэлж, хэрэглээ сэргэх хандлага үргэлжилж байгаа нь худалдаа, үйлчилгээний салбарын өсөлтийг тэтгэнэ гэж үзлээ. Харин өвөлжилт хүндэрсэнтэй холбоотойгоор малын тоо толгой буурсан нь хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг бууруулах, үүнийг дагаад мах бэлтгэл өмнөх оноос буурч, боловсруулах салбарын өсөлтийг өмнөх оноос сааруулахаар байна. Ирэх онд цаг агаарын нөхцөл байдал олон жилийн дунджийн орчимд байна гэж үзсэнээр хөдөө аж ахуйн салбарын өсөлт нэмэгдэнэ гэж үзэв. Батлагдсан төсвөөр төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлууд нэмэгдэхээр байгаа нь дотоод эрэлтийг урамшуулах, импортыг нэмэгдүүлэх нөлөөтэй тул барилга, үйлчилгээ, бүтээгдэхүүний цэвэр татварын орлогын өсөлт энэ оноос сайжрахаар авч

үзлээ. Ийнхүү уул уурхайн бус салбарын өсөлт ирэх онд нэмэгдэж, потенциал түвшнээсээ давах бол 2025 оноос хөрөнгө оруулалт буурах, төсвийн төлөв чангарах нөлөөгөөр эргээд саарах төлөвтэй байна.

Нийт эрэлт

Хувийн болон улсын секторын хэрэглээ, уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өмнөх төсөөллөөс нэмэгдсэнээр нийт эрэлтийн төсөөлөл өмнөхөөс сайжирлаа (Хүснэгт 2.2).

Дотоод эрэлт: Энэ онд төрийн байгууллагын хэрэглээ нэмэгдэж байгаа ч өрхийн хэрэглээний өсөлт өмнөх оноос бага байх, хөрөнгийн нийт хуримтлал агших нөлөөгөөр дотоод эрэлтийн өсөлт саарах төлөвтэй байна.

ХАА-н салбарын уналт үргэлжлэх, түүхий эдийн экспорт нэмэгдэх нөлөөгөөр материаллаг эргэлтийн хөрөнгө өмнөх оноос агшиж, хөрөнгийн нийт хуримтлал буурах хүлээлт хадгалагдаж байна. Түүнчлэн төсвийн хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа ч ГШХО өмнөх оноос буурах, барилгын томоохон төслүүд өмнөх онд хэрэгжиж дууссан зэргээс үүдэн үндсэн хөрөнгийн хуримтлалтын бодит өсөлт өмнөх оноос бага байх төлөвтэй байна.

Ирэх жил цаг агаар хэвийн байна гэж үзсэнээр биологийн өсөж үрждэг хөрөнгө, улмаар материаллаг эргэлтийн хөрөнгө сайжрах, төрийн болон өрхийн хэрэглээний өсөлт нэмэгдэн дотоод эрэлт эдийн засгийн өсөлтийг тэтгэх хүлээлттэй байна. Харин 2025 онд хөрөнгө оруулалт хумигдах, төсвийн төлөв чангарах төсөөлөлтэй байгаа тул дотоод эрэлт идэвхжихээргүй байна.

Цэвэр экспорт: Экспортын өсөлт энэ онд импортын өсөлтийг давж цэвэр экспорт эдийн засгийн өсөлтөд голлох эерэг нөлөөг үзүүлэхээр байна. Тодруулбал, уул уурхайн бүтээгдэхүүн тэр дундаа нүүрсний

экспортын биет хэмжээний өндөр өсөлт нь экспортын орлогын төсөөллийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байна. Нөгөө талаас, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг дагаад машин тоног төхөөрөмж, дизель түлшний хэрэглээ нэмэгдэж, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт нэмэгдэх төлөвтэй бол аж үйлдвэрлэлийн орц бүтээгдэхүүний импорт буурах хандлага үргэлжлэх төлөвтэй байна. Ирэх жил гол нэрийн экспортын түүхий эдийн биет хэмжээ энэ оны түвшинд байх хүлээлттэй ч эдийн засгийн идэвхжил, төсвийн тэлэлт нь импортыг нэмэгдүүлэх, мөн энэ оны өндөр экспортын суурь үеийн нөлөөгөөр экспортын өсөлт саарч улмаар цэвэр экспорт өсөлтийн төлөвт сөрөг нөлөө үзүүлэхээр байна. 2025 онд Оюу толгойн зэсийн баяжмалын экспорт нэмэгдэх, түүхий эдийн үнэ түүхэн дунджаас өндөр түвшинд хадгалагдах нь цэвэр экспортыг өсгөх хүлээлттэй байна.

Хүснэгт 2.2 Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл, өсөлтийн бүрэлдэхүүнээр

	2022	2023*	2024*	2025*
		төсөөлөл		
ДНБ-ий өсөлт	5.0	6.9	6.2	5.3
Дотоод эрэлт	11.4	-1.5	12.7	-2.6
Цэвэр экспорт	-6.4	8.4	-6.5	7.9

Эх сурвалж: Монголбанк


Эдийн засгийн цаашдын төлөвт нөлөөлж болзошгүй тодорхой бус байдал

Эрсдэл, тодорхой бус байдал	Магадлал	Нөлөө
БНХАУ-ын дотоодын нүүрсний олборлолт нэмэгдэж байгаа нь нүүрсний экспорт энэ оны өндөр түвшинд удаан хугацаанд хадгалагдахгүй байх эрсдэлийг үүсгэж болзошгүй. Энэ нь манай улсын экспортын орлого буурч, төсвийн орлого төлөвлөгөөнөөс дутах, цаашлаад эдийн засгийн өсөлтийн төлөвт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.	Өндөр	Өндөр (сөрөг)
БНХАУ-ын эдийн засгийн үйл ажиллагаа удааширч, үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт үргэлжилж байна. Засгийн газраас дэмжлэгийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа ч орон сууцны эрэлт сул хэвээр байгаа бөгөөд энэ нь удаан хугацаанд үргэлжлэх төлөвтэй байна. Улмаар гангийн эрэлт буурах, коксжих нүүрс, төмрийн хүдэр зэрэг манай улсын экспортын гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнэ буурах эрсдэлийг дагуулна. Энэ нь төлбөрийн тэнцлийн алдагдал тэлэх, гадаад валютын нөөц буурах, төсвийн орлого төлөвлөгөөнөөс дутаж, санхүүжилтийн шаардлагууд нэмэгдэх зэрэг эдийн засгийн хүндрэлүүдийг үүсгэж болзошгүй байна.	Дунд	Дунд (сөрөг)
Ирэх оны сонгуультай холбоотойгоор төсвийн зардал батлагдсан дүнгээс нэмэгдэх, хуулийн хязгаарыг давж алдагдал огцом тэлэх зэрэг нь эдийн засаг, санхүүгийн орчныг муутгаж, хөрөнгө оруулагчдын итгэлд сөргөөр нөлөөлөх, зээлжих зэрэглэл буурах, эдийн засгийн өсөлт хүлээлтээс муудах зэрэг эрсдэлийг дагуулна.	Бага	Дунд (сөрөг)
Геополитикийн зөрчил олон орнуудыг хамрах, гүнзгийрэх эрсдэл байсаар байна. Ойрхи-Дорнод дахь улс орнуудын мөргөлдөөн эрчимжиж, ОХУ-Украины дайны явц үргэлжилсээр байгаа нь дэлхийн эдийн засгийн төлөвт сөргөөр нөлөөлж, тодорхой бус байдлыг нэмэгдүүлсээр байна.	Дунд	Дунд (сөрөг)

Потенциал үйлдвэрлэл⁶

Олон хувьсагчийн Калман фильтр, нэг хувьсагчийн HP фильтр, Үйлдвэрлэлийн функцийн арга зэрэг ялгаатай аргуудаар тооцсон потенциал үйлдвэрлэлийн өсөлт харьцангуй ойролцоо түвшинд байна.

Зураг 2.2 Потенциал үйлдвэрлэлийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Потенциал үйлдвэрлэлийн өсөлт сүүлийн 2 жилд нэмэгдэх хандлага ажиглагдаж, 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 5 хувийн орчимд байна. Үүнээс үйлдвэрлэлийн функцийн аргачлалаар тооцсон потенциал үйлдвэрлэлийн өсөлтөд капитал хуримтлал, хөдөлмөр, бүтээмж зэрэг үйлдвэрлэлийн орцууд эерэг нөлөөтэй байна.


Үйлдвэрлэлийн зөрүү⁷

Ковид-19 цар тахал, ОХУ-Украины дайн, Хятадын “Тэг-Ковид” бодлого зэрэг дараалсан шокуудын нөлөөгөөр дотоод эдийн засгийн идэвхжил хумигдаж, үйлдвэрлэлийн зөрүү 2020-2022 онд сөрөг түвшинд хадгалагдлаа. Харин энэ онд уул уурхайн салбар сэргэж, дотоод эдийн засгийн идэвхжил нэмэгдэж байгаагаас шалтгаалан үйлдвэрлэлийн сөрөг зөрүү багасч байна. Тайлант улиралд үйлдвэрлэлийн сөрөг зөрүү өмнөх улирлаас

⁶ Үйлдвэрлэлийн хүчин зүйлс хэвийн ашиглалттай үед бий болох үйлдвэрлэлийг потенциал үйлдвэрлэл гэнэ. Потенциал үйлдвэрлэл нь шууд ажиглагдахгүй тул түүхэн утгын трендээр ойролцоолон тооцдог.

багасахад уул уурхайн салбарын эрчимтэй өсөлт гол нөлөөтэй байна. Түүнчлэн тээвэр, худалдаа, үйлчилгээний салбарт ажиллагсадын тооны өсөлт тайлант улиралд голлон сайжирч, уул уурхайн бус салбарын өсөлт нэмэгдсэн нь үйлдвэрлэлийн сөрөг зөрүү буурахад эерэгээр нөлөөлөв (Зураг 2.3).

Зураг 2.3 Үйлдвэрлэлийн зөрүү⁸



Эх сурвалж: Монголбанк

2.2. Эдийн засгийн өсөлтийн гүйцэтгэл

Гуравдугаар улирлын эдийн засгийн өсөлтийг тоймлон авч үзвэл:

- Уул уурхай, тээврийн салбар эдийн засгийн өсөлтийг голлон тэтгэсэн хэвээр байна;
- Уул, уурхайн бус салбарын идэвхжил бага зэрэг нэмэгдлээ;
- Өрхийн орлогын өсөлт хэрэглээг дэмжиж байна.

Нийт нийлүүлэлт


Нийт үйлдвэрлэл III улиралд 7.8 хувь, эхний гурван улирлын нийлбэр дүнгээр 6.9 хувиар өслөө (Зураг 2.4). Уул уурхай, түүнийг дагасан тээврийн салбарын үйл ажиллагаа хэвийн үргэлжилж эдийн засгийн өсөлтийг голлон тэтгэсэн хэвээр байна. Мөн уул уурхайн бус салбаруудын хувьд идэвхжил

⁷ Үйлдвэрлэлийн зөрүү нь потенциал үйлдвэрлэл болон бодит ДНБ-ий зөрүүгээр тодорхойлогдоно.

⁸ GAP загварын үр дүн

тайлант улиралд бага зэрэг нэмэгдэв. Харин өнгөрсөн өвөл, хаврын цаг агаарын таагүй нөхцөлөөс үүдэлтэй малын тоо, толгойн зүй бус хорогдол энэ оны турш эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлсөөр байна.

Зураг 2.4 Уул уурхай болон тээврийн салбар ЭЗӨ-ийг голлон тэтгэв



* - Боловсруулах, эрчим хүч, барилга, мэдээлэл холбоо, бусад үйлчилгээ, бүтээгдэхүүний цэвэр татвар


Эх сурвалж: YCX

Нийт үйлдвэрлэлийн III улирлын өсөлтийг салбаруудаар авч үзвэл:

Тайлант улиралд уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл тэр дундаа нүүрсний олборлолт сайн байж, уул уурхайн салбар эдийн засгийн өсөлтийн 2.4 нэгж хувийг бүрдүүлэв. Тодруулбал, нүүрсний олборлолт өнгөрсөн оны мөн үеэс 2.2 дахин нэмэгдэж, III улиралд 21.4 сая тоннд хүрчээ (Зураг 2.5).

Гадаад эрэлт сайн байж, уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэний зэрэгцээ дамжин өнгөрөх тээвэр оны турш өндөр байгаа нь тээврийн салбарын орлогыг голлон дэмжлээ. Тухайлбал, III улиралд 27 орчим сая тонн ачаа тээвэрлэсэн нь түүхэн дээд үзүүлэлт болж, ачаа тээврийн 80 орчим хувь нь уул уурхайн бүтээгдэхүүн байв.


Зураг 2.5 Уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хэвийн үргэлжлэв



Эх сурвалж: YCX, Монголбанк

Аж үйлдвэр болон үйлчилгээний бусад салбаруудын идэвхжил II улирлаас аажим нэмэгдэж, эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлж байна. Аялал жуулчлалын салбарын идэвхжиж, үүнтэй зэрэгцээд III улиралд байр орон сууц, нийтийн хоол, урлаг үзвэрийн үйлчилгээ нэмэгдлээ. Мөн боловсруулах салбарт хүнсний бүтээгдэхүүн болон хөнгөн үйлдвэрлэл сайн байв (Зураг 2.6).

Зураг 2.6 Уул уурхайн бус салбаруудын өсөлт, улирлаар



* - Боловсруулах, эрчим хүч, барилга, худалдаа, мэдээлэл холбоо, бусад үйлчилгээ

Эх сурвалж: YCX


Хөдөө аж ахуйн салбар III улиралд 8.7 хувиар буурлаа. Малын тоо, толгойн сөрөг өөрчлөлт хөдөө аж ахуйн салбарт оны турш сөрөг нөлөө үзүүлж байна. Нөгөөтээгүүр,

ХАА-н салбарын 10 орчим хувийг бүрдүүлдэг газар тариалангийн салбар энэ онд өсөх төлөвтэй боллоо. Ургацын урьдчилсан мэдээгээр улаанбуудай, хүнсний ногооны ургац сайн байгаа нь газар тариалангийн үйлдвэрлэлд эергээр нөлөөлөхөөр байна.

Нийт эрэлт

Нийт эрэлт энэ оны III улиралд 8.7 хувь, эхний 3 улирлын нийлбэр дүнгээр 7.1 хувиар өслөө. Энэхүү өсөлтийг 1) уул уурхайн бүтээгдэхүүний экспорт, 2) эцсийн хэрэглээ голлон бүрдүүлж байна (Зураг 2.7).

Зураг 2.7 Хэрэглээ болон экспорт нийт эрэлтийг дэмжиж байна




Эх сурвалж: УСХ

Нийт эрэлтийн III улирлын өсөлтийг бүлгүүдээр авч үзвэл:

Тайлант улиралд бараа, үйлчилгээний экспорт жилийн 23.2 хувиар өсөж, нийт эрэлтэд 16.6 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлээ. Тодруулбал, нүүрсний экспортын биет хэмжээ III улиралд 18.5 сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 69 хувиар нэмэгдсэн нь өсөлтийг голлон тайлбарлав (Зураг 2.8).


Зураг 2.8 Нүүрсний тээвэрлэлт хурдацтайгаар нэмэгдэж байна



Эх сурвалж: ГЕГ

Энэ оны I улиралд унаад байсан өрхийн хэрэглээ эргэн сэргэж III улиралд жилийн 9.5 хувиар нэмэгдэв. Энэ нь нийт өсөлтийн 6.0 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Тайлант улиралд цалин эрчтэй өссөн нь өрхийн бодит орлогод⁹ эергээр нөлөөлж жилийн 12.8 хувиар өсөв.

Зураг 2.9 Өрхийн хэрэглээ эргэн сэргэлээ



Эх сурвалж: УСХ

Хөрөнгийн нийт хуримтлал тайлант улиралд 13 орчим хувиар буурч, нийт эрэлтийн өсөлтөд 5.5 нэгж хувийн сааруулах нөлөө үзүүлэв. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт эрчтэй үргэлжилж, нөөц буурсан, малын тоо толгойн бууралт нь эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтөд сөргөөр нөлөөлөв.

⁹ Өрхийн нэрлэсэн орлогыг ХҮИ-ээр засварлан бодит орлогыг тооцов.

3. ДОТООД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

3.1. Хөдөлмөрийн зах зээл

Хөдөлмөрийн захын III улирлын төлөвийг тоймлон авч үзвэл:

- Ажиллах хүчний оролцооны түвшин цар тахлын өмнөх түвшнээс бага хэвээр байна.
- Ажилгүйдлийн түвшин статистик бүртгэж эхэлснээс хойших түүхэн доод хэмжээнд хүрч буурав.
- Бодит цалин жилийн өмнөх үеэс 16.2 хувиар өсөв.
- Нэгж хөдөлмөрийн зардал нэмэгдлээ.

Оны эхний хагаст бууралттай байсан хөдөлмөрийн насны хүн ам тайлант улиралд өссөн дүнтэй гарлаа. Үүнийг бүрэлдэхүүн хэсгүүдээр нь ангилж үзвэл ажиллах хүчний тоо эргэн өссөн нь голлон нөлөөлөв (Хүснэгт 3.1).


Хүснэгт 3.1 Хөдөлмөрийн насны хүн амын шилжилт хөдөлгөөн

мянган хүн	2019Q3	2022Q3	2023Q2	2023Q3
Хөдөлмөрийн насны хүн ам	2133.5	2126.5	2127.3	2136.62
Ажиллах хүч	1282.5	1259.6	1231.2	1259.4
Ажиллагчид	1155.9	1191.5	1160.3	1193.3
Бүрэн хөдөлмөр эрхлэлт	1145.1	1177.4	1153.9	1187.2
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт	10.9	14.0	6.4	6.1
Ажилгүй хүн	126.6	68.1	70.9	66.0
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	851.0	866.9	896.1	877.3
Боломжит ажиллах хүч	51.4	41.4	25.4	39.9
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	799.6	825.6	870.7	837.4

Эх сурвалж: ҮСХ

Ажилгүй хүмүүсийн тоо буурах хандлага үргэлжилж, тайлант улиралд өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар буурч 66 мянган хүнд хүрлээ. Энэ нь цар тахлын өмнөх үе буюу 2019 оны 3-р улиралтай харьцуулахад 48 хувиар бага үзүүлэлт болж байна. Харин ажиллагчдын тоо цар тахлын өмнөх үе буюу 2019 оны 3-р улиралтай харьцуулахад 37.4 мянган хүнээр нэмэгдсэн байна (Хүснэгт 3.1).


Зураг 3.1 Хөдөлмөрийн насны хүн амын жилийн өөрчлөлт, бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: ҮСХ

Ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо өмнөх жилийн мөн үеэс 1.2 хувиар өсөв. Статистик мэдээллээс үзэхэд 2023 оны 3-р улиралд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, суралцагчдын тоо, тэтгэврийн насны хүн ам нэмэгдсэн нь нөлөөлжээ (Зураг 3.2).


Зураг 3.2 Ажиллах хүчнээс гадуурх хүн амын жилийн өөрчлөлт, бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: ҮСХ

Ажиллах хүчний оролцооны түвшний жилийн өөрчлөлтийг авч үзвэл сүүлийн 4 улирал дараалан буурлаа. Цар тахлын өмнөх жил энэ үзүүлэлт 60.1 хувьтай тэнцүү байсан бол тайлант улиралд 58.9 хувь байна. Харин ажилгүйдлийн түвшин 5.2 хувь буюу статистик бүртгэж эхэлснээс хойших хамгийн доод түвшинд хүрсэн байна (Зураг 3.3).

Зураг 3.3 Хөдөлмөрийн захын үндсэн үзүүлэлтүүд




Эх сурвалж: УСХ

Ажил эрхлэлт, нийгмийн даатгал

Нийт ажиллагчдын тооны жилийн өөрчлөлт 2023 он гарсаар эхний 2 улирал дараалан буурсан бол 3-р улиралд өссөн байна. Тодруулбал, уул уурхай, барилга, худалдаа, тээврийн салбарт ажиллагчдын тоо нэмэгдэж хөдөө аж ахуй, боловсруулах, бусад үйлчилгээний салбарт ажиллагчид буурчээ (Зураг 3.4).

Нийгмийн даатгалд хамрагдагчдын тоо 2023 оны 9-р сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 9.5 хувиар буураад байна. Үүнд албан журмаар даатгуулагчдын тоо өмнөх оны мөн үеэс 24.4 хувиар буурсан нь нөлөөлөв.

Зураг 3.4 Ажиллагчдын тооны жилийн өөрчлөлт, салбараар



Эх сурвалж: УСХ

Цалин, өрхийн орлого

Улсын дундаж цалин 2023 оны 3-р улиралд жилийн өмнөхөөс 27.7 хувиар өссөн бол медиан цалин 34.5 хувиар өслөө. Ингэснээр дундаж цалин 2009 мянган төгрөг¹⁰, медиан цалин 1556 мянган төгрөгтэй тус тус тэнцэж байна. Цалин ийнхүү нэмэгдсэн нь өрхийн орлого нэмэгдэх шалтгаан болж байна. Сүүлийн 5 улиралд нэрлэсэн цалин өндөр өсөж, инфляц буурах хандлагатай байгаагаас шалтгаалж бодит цалингийн өсөлт эрчимжиж байна (Зураг 3.5).

Зураг 3.5 Цалингийн өсөлт ба өрхийн орлогын өсөлт



Эх сурвалж: УСХ

Эдийн засгийн голлох салбаруудаар авч үзвэл төрийн удирдлага (51%), хөдөө аж ахуй (32%), уул уурхай (27%), тээвэр ба агуулах (27%)-н салбарт ажиллагчдын дундаж нэрлэсэн цалин хамгийн өндөр өсөлттэй байв. Харин боловсруулах (23%), худалдаа (20%), мэдээлэл холбоо (20%)-ны салбарт алба хаагчдын цалингийн өсөлт харьцангуй бага байна.

Нэгж хөдөлмөрийн зардал


Нэгж хөдөлмөрийн зардал¹¹ сүүлийн 7 улирал дараалан жилийн өмнөх үеэс нэмэгдэв. Тодруулбал, цалингийн өсөлт бүтээмжийн өсөлтөөс үлэмж өндөр байгаа нь үйлдвэрлэлийн зардлыг нэмэгдүүлж, улмаар

¹⁰ 2019 оны мөн үетэй харьцуулахад 72 хувиар өссөн

¹¹ Нэгж ДНБ-д ногдох дундаж хөдөлмөрийн өртөг буюу цалин.

үнэ өсөх гол шалтгаан болж болзошгүй байна (Зураг 3.6).

Зураг 3.6 Нэгж хөдөлмөрийн дундаж зардлын жилийн өөрчлөлт, бүрэлдэхүүнээр



3.2. Мөнгө, санхүүгийн зах зээл

3.2.1. Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд

Мөнгөний нийлүүлэлт болон зээлийн өсөлт эрчимжих хандлага үргэлжилж байна.


Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт үргэлжлэн эрчимжиж 2023 оны 10 дугаар сард 23.5 хувьд хүрлээ. Үүнд, төлбөрийн тэнцэлтэй холбоотой банкны системийн гадаад цэвэр актив (ГЦА) нэмэгдэж, зээлийн өсөлт алгуур сэргэж байгаа нь голлон нөлөөлөв. Тухайлбал, мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн 21.4 нэгж хувийг ГЦА, 13.9 нэгж хувийг зээлийн өсөлт тайлбарлаж байгаа бол Засгийн газрын цэвэр зээл (ЗГЦЗ) 9.7 нэгж хувийн бууруулах нөлөө үзүүлэв.

Нэгдсэн төсвийн тэнцэл 2023 оны 3 дугаар улиралд 610 тэрбум төгрөгийн ашигтай байгаагаас ЗГЦЗ үргэлжлэн буурав. Харин 10 дугаар сард Монголбанк дахь Засгийн газрын харилцах дахь эх үүсвэрээс Евро бондын эргэн төлөлтийг санхүүжүүлсэн¹² нөлөөгөөр ЗГЦЗ 10 дугаар сард нэмэгдэж,

¹² МУХБ-ны Самурай бондын төлбөр 30 тэрбум иенийг 2022 оны 12 дугаар сард Засгийн газрын харилцахад урьдчилан байршуулсан. Уг эх үүсвэрээр 2023 оны 10

мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд үзүүлэх сөрөг нөлөө бага зэрэг буурлаа.

Зураг 3.7 М2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, актив тал



Төгрөгийн эх үүсвэр үргэлжлэн нэмэгдэж байгаа нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлт эрчимжихэд голлон нөлөөллөө. Тухайлбал, мөнгөний нийлүүлэлт жилийн 23.5 хувиар өсөхөд төгрөгийн эх үүсвэр 18.5 нэгж хувь, гадаад валютын эх үүсвэр 4.7 нэгж хувийн нөлөөг үзүүлжээ.

Зураг 3.8 М2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, пассив тал



Банкны системийн эх үүсвэрийн долларжилт 2023 оны 3 дугаар улиралд 31.1

дугаар сард Евро бондын эргэн төлөлтийн зарим хэсгийг санхүүжүүлэв

хувьд¹³ хүрээд байсан бол 10 дугаар сард 30.4 хувьд хүрч буурлаа. Энэ нь өмнөх оны мөн үеэс 2.3 нэгж хувиар бага дүн бөгөөд ханшийн нөлөөг хасаж тооцвол 25.1 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.5 нэгж хувиар буурсан байна (Зураг 3.9).

Зураг 3.9 Банкуудын зээл, хадгаламжийн долларжилт




Эх сурвалж: Монголбанк

Банкны системийн зээлийн жилийн өсөлт 2023 оны 10 дугаар сард 15.7 хувьд хүрч, оны эхнээс сэргэх хандлагатай байна (Зураг 3.12). Зээлийн зориулалтаар нь ангилж харвал хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээл жилийн 38 хувиар өсөж¹⁴, нийт зээлийн өсөлтийг голлон бүрдүүлж (10.1 нэгж хувь) байна. Ипотекийн зээлийн¹⁵ өсөлт 14-16 хувь орчимд тогтвортой байгаа бол бизнесийн зээл өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар өсөж, өсөлт нь нам түвшинд байна. Эдийн засгийн салбараар авч үзвэл, дийлэнх салбаруудын зээл өмнөх оны мөн үеэс өссөн бөгөөд тэр дундаа худалдаа, барилга, үйлчилгээний салбарын зээлийн өсөлт бизнесийн зээлийн өсөлтийг голлон бүрдүүлэв. Харин уул уурхайн салбарын

зээл өмнөх оны мөн үеэс буурсан¹⁶ хэвээр байна (Зураг 3.10).

Валютын төрлөөр нь авч үзвэл төгрөгийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 16.5 хувиар, гадаад валютын зээлийн үлдэгдэл 2.9 хувиар нэмэгдэж, зээлийн долларжилт 5.7 хувьд хүрэв (Зураг 3.9).

Зураг 3.10 Арилжааны банкуудын зээлийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн



Эх сурвалж: Монголбанк

Банкны системийн зээлийн чанар төдийлөн өөрчлөлтгүй байв. Чанаргүй зээлийн үлдэгдэл энэ онд 2.2 их наяд орчимд, нийт зээлийн багцад эзлэх хувь нь 8-10 хувьд харьцангуй тогтвортой байлаа. Харин чанаргүй зээлийн өсөлт тайлант улиралд огцом буурсан нь 2022 оны 3 дугаар улиралд банкуудад активын чанарын үнэлгээ хийж, чанаргүй зээлийн үлдэгдэл өссөн суурь үеийн нөлөөнөөс шалтгаалж байна. Улмаар чанаргүй зээлийн үлдэгдэл 2023 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 472 тэрбум төгрөг буюу 17.8 хувиар буурав¹⁷ (Зураг 3.11).

¹³ Улсын байгууллага болон хувийн хэвшлийн гадаад валютын харилцах тайлант улиралд нэмэгдсэн нь эх үүсвэрийн долларжилт нэмэгдэхэд нөлөөллөө.


¹⁴ Хэрэглээний зээлийн өсөлтийн 19.8 нэгж хувийг цалингийн зээл, 10.7 нэгж хувийг тэтгэврийн зээл бүрдүүлж байна.

¹⁵ Ипотекийн зээлээр баталгаажуулсан бонд оруулж тооцсон.

¹⁶ Уул уурхайн салбарын зээл жилийн 19.2 хувиар буурсан нь нийт зээлийн өсөлтийг 2.2 нэгж хувиар бууруулав.


¹⁷ Бүх салбаруудад чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс буурав.

Зураг 3.11 Банкны системийн чанаргүй зээлийн жилийн өсөлт, эдийн засгийн салбаруудаар



Банкны системийн анхаарал хандуулах зээлийн өсөлт 2023 оны 1 дүгээр улирлаас хойш саарах хандлагатай байна (Зураг 3.12). Тодруулбал, анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 166 тэрбум төгрөг буюу 13.5 хувиар нэмэгдэж, 1.4 их наяд төгрөгт хүрэв. Үүнд, үйлчилгээ, худалдаа, боловсруулах, барилгын салбаруудын анхаарал хандуулах зээл өмнөх оны мөн үеэс өссөн бол хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээл, уул уурхайн салбарын анхаарал хандуулах зээл буурчээ. Улмаар анхаарал хандуулах зээл нийт зээлийн багцын 5.3 хувийг бүрдүүлж байна.

Зураг 3.12 Банкны системийн анхаарал хандуулах зээлийн жилийн өсөлт, эдийн засгийн салбаруудаар



¹⁸ 2023 оны 2 дугаар улиралтай харьцуулахад

¹⁹ Банкуудын зах зээлийн хүүгээс доогуур буюу Засгийн газар болон Монголбанкнаас хэрэгжүүлж буй хөтөлбөр,

3.2.2. Хүү

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2023 оны 4 дүгээр улирлын ээлжит хурлаар бодлогын хүүг 13 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа. Тайлант хугацаанд банк хоорондын захын хүүнүүд хүүний коридорын голчийн орчимд тогтвортой байв.

Зураг 3.13. БХЗ-ын хэлцлийн хүү



Банк хоорондын жигнэсэн дундаж хүү 2023 оны 10 дугаар сард 13.1 хувьд хүрч, өмнөх улирлаас¹⁸ 0.16 нэгж хувиар өсжээ. Үүнд, банк хоорондын хадгаламжийн хүү 13.42 хувьд хүрч, өмнөх улиралтай харьцуулахад 0.57 нэгж хувиар өссөн бол ТБҮЦ барьцаалсан репо хэлцэл, ТБҮЦ-ны шууд хэлцэл, овернайт зээлийн хүүнүүд 13.0 хувийн орчимд, өөрчлөлт бага байна (Зураг 3.13).

Банкуудын шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү өмнөх улирлаас 1.01 нэгж хувиар өсөж 11.92 хувьд, шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү 0.06 нэгж хувиар буурч, 16.27 хувьд хүрэв. Харин хөнгөлөлттэй зээлийг¹⁹ хасаж тооцвол шинээр олгосон зээлийн хүү өмнөх улирлаас 0.18 нэгж хувиар буурч, 16.67 хувьд хүрсэн байна. Ийнхүү хадгаламжийн

төлөвлөгөөний хүрээнд хөнгөлөлттэй нөхцөлтэй олгосон зээл

хүү өсөж, зээлийн хүү буурсан тул зээл, хадгаламжийн хүүний зөрүү 4.35 хувьд хүрч, өмнөх улирлаас 1.06 нэгж хувиар буурлаа (Зураг 3.14).

Зураг 3.14 Шинээр олгосон зээлийн болон шинээр татсан хадгаламжийн хүү




* Нийт зээлийн хүүнээс тооцсон

Эх сурвалж: Монголбанк

Шинээр олгосон гадаад валютын зээлийн хүү болон шинээр татсан гадаад валютын хадгаламжийн хүү өснөх улирлаас нэмэгдэв. Тодруулбал, шинээр татсан гадаад валютын хадгаламжийн хүү 2023 оны 10 дугаар сард 3.61 хувьд хүрч, өмнөх улирлаас 0.8 нэгж хувиар өссөн байна. Харин шинээр олгосон гадаад валютын зээлийн хүү 10.85 хувьд хүрсэн нь өмнөхөөс улирлаас 1.01 нэгж хувиар өндөр дүн юм. Улмаар гадаад валютын зээл, хадгаламжийн хүүний зөрүү өмнөх улирлаас 0.21 нэгж хувиар өсөж, 7.24 хувьд хүрлээ (Зураг 3.15).

Зураг 3.15. Шинээр олгосон зээлийн болон шинээр татсан хадгаламжийн хүү, гадаад валют



Эх сурвалж: Монголбанк

3.2.3 Валютын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2023 оны сүүлийн хагасд 3450 төгрөгийн орчимд тогтворжиж, 9 болон 10 дугаар сарын байдлаар бага зэрэг чангараад байна (Зураг 3.16).

Экспортын орлого нэмэгдэн, гадаад валютын цэвэр орох урсгал 2023 оны эхнээс хойш эерэг байгаа нь ханш тогтвортой байх нөхцөл болж байна.


Зураг 3.16 Төгрөгийн ам.доллартай харьцах ханш



Эх сурвалж: Монголбанк

Гадаад худалдааны эргэлтээр жигнэж тооцсон төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш (NEER) энэ оны 6 дугаар сараас чангарч эхлэн 10 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 4.6 хувиар чанга тогтлоо. Тодруулбал, төгрөгийн ханш өмнөх оны мөн үеэс ам.долларын эсрэг 1.7 хувиар, юанийн эсрэг 0.7 хувиар, еврогын эсрэг 8.6 хувиар тус тус суларсан бол рублийн эсрэг 32.0 хувиар чангарав (Зураг 3.17).


Зураг 3.17 Төгрөгийн гол валютуудтай харьцах ханш, нэрлэсэн үйлчилж буй ханшийн (NEER) жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанк

Нэрлэсэн ханш чангарсан нөлөөгөөр бодит үйлчилж буй ханш энэ оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс (12.1 хувиар) чангарлаа (Зураг 3.18). Гадаад үнэтэй харьцуулахад дотоод үнэ өндөр хэвээр байна.

Зураг 3.18 Төгрөгийн бодит үйлчилж буй ханшийн жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн харьцангуй өгөөж эерэг түвшинд хадгалагдсан хэвээр 2023 оны 10 дугаар сарын байдлаар 1.1 хувьтай байна (Зураг 3.19). Төгрөгийн харьцангуй өгөөж эерэг түвшинд хүрснээр төгрөгийн харилцах, хадгаламж өсөн, валютын харилцах, хадгаламжийн өсөлт буурч байна.

Зураг 3.19 Төгрөгийн харьцангуй өгөөж



Эх сурвалж: Монголбанк

3.2.4. Хөрөнгийн зах зээл

Тайлант улиралд орон сууцны үнэ тогтвортой хадгалагдаж, хөрөнгийн захын идэвхжил буурлаа.

Орон сууцны зах зээл

“Тэнхлэг зууч ХХК” компанийн мэдээллээр орон сууцны болон түрээсийн үнэ сүүлийн 6 улирлын турш харьцангуй тогтвортой түвшинд хадгалагдаж байна. Тухайлбал, орон сууцны үнэ өмнөх улирлаас 0.1 хувиар ялимгүй нэмэгдсэн бол түрээсийн үнэ өмнөх улирлаас өөрчлөгдөөгүй байна. Ийнхүү орон сууц болон түрээсийн үнийн өөрчлөлт бага байснаар үнэ, түрээсийн зөрүү үргэлжлэн нам түвшинд хадгалагдлаа (Зураг 3.20).

Зураг 3.20 Орон сууцны үнэ ба түрээсийн үнийн жилийн өсөлт




Эх сурвалж: YCX, Тэнхлэг-Зууч

Орон сууцны үнэ ийнхүү тогтвортой байхад орон сууцны ипотекийн зээлийн хэмжээ (хөнгөлөлттэй) буурсан болон импортын

барааны үнийн өсөлт саарч, барилгын материалын нийлүүлэлт тогтворжсоноор барилгын өртгийн индексийн өсөлт сүүлийн 2 улирал дараалан буурч байгаа нь нөлөөлж байна.

Орон сууцны үнэ өөрчлөлтгүй байгаа бол өрхийн нэрлэсэн орлого тайлант улиралд өмнөх оны мөн үеэс 23.8 хувиар, өмнөх улирлаас 11.8 хувиар өссөнөөр үнэ-орлогын харьцаа буурлаа. Энэ харьцаа үзүүлэлт буурч байгаа нь иргэд, өрхийн орон сууц худалдан авах чадвар нэмэгдэж байгааг илтгэж байна. Мөн орон сууц болон түрээсийн үнэ аль аль нь өөрчлөлт багатай байснаар үнэ-түрээсийн харьцаа тогтвортой байх хандлага үргэлжиллээ. Энэхүү харьцаа нь сүүлийн 5 улирлын турш тогтвортой байгаа нь орон сууцны үнэ хэт өсөх эрсдэл сүүлийн улирлуудад нэмэгдээгүйг харуулж байна (Зураг 3.21).

Зураг 3.21 Үнэ-орлого ба үнэ-түрээсийн харьцаа




Эх сурвалж: ҮСХ, Тэнхлэг-Зууч

Тайлант улиралд барилгын өртгийн индекс өмнөх улирлаас 5 хувиар буурлаа (Зураг 3.23). Барилгын өртөг ийнхүү өмнөх улирлаас буурахад төгрөгийн гадаад валюттай харьцах ханш чангарч, импортын бараа, материалын үнийн өсөлт буурсан, дотоодын цементний үнийн өсөлт сүүлийн саруудад тогтворжиж, материалын өртөг буурсан нь голлон нөлөөлж байна. Тодруулбал, бараа материалын өртөг өмнөх

улирлаас 10.4 хувиар буурч, нийт өсөлтөд үзүүлэх нөлөө 4.2 нэгж хувь болж буурлаа. Харин цалингийн зардал өмнөх улирлаас 3.6 хувиар өссөн ба нийт өсөлтийн 6.8 нэгж хувийг бүрдүүлэв (Зураг 3.22).

Зураг 3.22 Орон сууцны барилгын өртгийн индекс (БӨИ)




Эх сурвалж: ҮСХ

Хөрөнгийн зах зээл

Хөрөнгийн захын идэвхжил саарч байна. Тодруулбал, тайлант улиралд ТОП-20 индекс өмнөх улирлаас 2.1 хувиар буурч, хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 6.9 хувиар багаслаа.

АПУ ХК, Говь ХК, Голомт банк ХК зэрэг томоохон компаниудын хувьцааны үнэ буурч, ТОП-20 индекс өмнөх улирлаас саарлаа. Түүнчлэн, өмнөх улиралд системийн нөлөө бүхий арилжааны банкнууд анхдагч зах зээлд хувьцаагаа арилжаалсан нь хувьцааны арилжааны дүн болон нийт зах зээлийн үнэлгээ огцом өсөх шалтгаан болж, нийт зах зээлийн үнэлгээ өмнөх улиралд 10.9 их наяд төгрөгт хүрч байв. Харин 10 дугаар сард зах зээлийн үнэлгээ 10.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх улирлаас 700 тэрбум төгрөгөөр буурсан байна.


Зураг 3.23 Хөрөнгийн захын голлох үзүүлэлтүүд



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Тайлант улиралд үнэт цаасны арилжааны дүн 101.4 тэрбум төгрөг болж, өмнөх улирлаас 4 дахин, өмнөх оны дунджаас 30 хувиар тус тус буурлаа (Зураг 3.24). Үүнээс компанийн бондын арилжаа тайлант улиралд идэвхжсэн хэдий ч хувьцааны арилжаа буурсан дүнтэй байна.

Зураг 3.24 Нийт арилжаа, бүтцээр²⁰



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Тодруулбал, анхдагч зах зээлд Инвескор ББСБ нийт 20.0 тэрбум төгрөгийн, ЛэндМН ББСБ 9.0 тэрбум төгрөгийн, Ашид Капитал ББСБ 20.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл нийтэд арилжсан нь өмнөх улиралтай харьцуулахад 2.7 дахин өссөн дүн юм. Түүнчлэн, хоёрдогч зах зээлд нийт 10.7 тэрбум төгрөгийн үнийн дүн

бүхий компанийн бондын арилжаа хийгдэж, нийт компанийн бондын арилжаа өмнөх улирлаас 2.3 дахин нэмэгдлээ.

Харин хувьцааны арилжааны идэвх энэ улиралд бага байлаа. Өмнөх улиралд системийн нөлөө бүхий арилжааны банкнууд анхдагч зах зээлд нийт 313 тэрбум төгрөгийн үний дүн бүхий хувьцааны арилжаа хийж байсан бол тайлант улиралд анхдагч зах зээлд 10.99 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж, өмнөх улиралтай харьцуулахад арилжааны идэвх огцом буурлаа. Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны хувьд нийт 26.2 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн ба арилжааны идэвх өмнөх улирлаас мөн суларсан байна.

ХБҮЦ-ны арилжааны хувьд анхдагч зах зээл болон хоёрдогч зах зээлийн арилжаа өмнөх улирлаас буурч, нийт хийгдсэн арилжааны дүн 2.5 тэрбум төгрөгт хүрсэн бол ХОС-ийн нийт 1.9 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж, арилжааны идэвх бага зэрэг нэмэгдэв.

3.3. Нэгдсэн төсөв болон Засгийн газрын өр

Нэгдсэн төсөв: Эхний 10 сарын байдлаар төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 46.2 хувиар өндөр төвлөрч, 18.2 их наяд төгрөгт хүрсэн бол зардал 20.8 хувиар өсөж буюу 16.9 их наяд төгрөг байв. Ийнхүү тэнцвэржүүлсэн тэнцэл тайлант сард 2.1 их наяд төгрөгийн ашигтай гарлаа (Хүснэгт 3.2).

Тэнцвэржүүлсэн орлого 2023 онд: Уул уурхайн экспортын таатай нөхцөл байдал, түүнийг дагасан эдийн засаг идэвхжил төсвийн орлогыг нэмэгдүүлж байна. Тухайлбал, оны эхний 10 сард ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, аж

²⁰ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ), Хөрөнгө оруулалтын сан (ХОС)

ахуй нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татварын орлого бүрдүүлэлт өндөр байж, татварын орлого өмнөх оноос 47.3 хувиар нэмэгдлээ (Зураг 3.25).

Хүснэгт 3.2 Төсвийн үндсэн үзүүлэлтүүд


Их наяд төгрөг	2022 Гүй.	2023 Тод.	2023.10 Гүй.
Нийт орлого	18.6	21.8	19.8
Сангийн орлого	1.4	1.0	0.8
Тэнцвэржүүлсэн орлого	17.2	20.8	19.0
Татварын орлого	15.6	18.9	17.6
Татварын бус орлого	1.6	1.9	1.3
Нийт зардал	18.2	22.4	16.9
Анхдагч зардал	17.4	21.3	15.9
Хүүний зардал	0.8	1.1	1.0
Нийт тэнцэл	0.4	-0.5	2.9
ДНБ-д эзлэх хувь	0.9%	-0.9%	0.0
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-1.0	-1.6	2.1
ДНБ-д эзлэх хувь	-2.1%	-2.6%	0.0
Анхдагч тэнцэл	-0.2	-0.5	3.1
ДНБ-д эзлэх хувь	-0.3%	-0.8%	0.1

Эх сурвалж: Сангийн яам

Нийт зардал, цэвэр зээл 2023 онд: Эхний 10 сарын төсвийн зардал өмнөх оны мөн үеэс 20.8 хувиар буюу 2.9 их наяд төгрөгөөр өндөр байв. Үүнээс урсгал зардал 1.9 их наяд төгрөгөөр нэмэгдсэний 754 тэрбум төгрөгийг бараа, үйлчилгээний зардалд зарцуулжээ. Цалингийн зардал эхний 10 сарын байдлаар 416 тэрбум төгрөгөөр өссөний 290 орчим тэрбум төгрөг нь сүүлийн 4 сард буюу төсвийн тодотголоос хойших хугацаанд үүсжээ.


Төсвийн хөрөнгө оруулалтын зардлын хувьд эхний 10 сард өмнөх оноос 34.9 хувь буюу 860 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. 2022 онтой харьцуулахад тоног төхөөрөмжийн зардал 185 хувь, бусад хөрөнгийн зардал 53.9 хувиар нэмэгдсэн нь гол нөлөөлөв (Зураг 3.27).

Зураг 3.25 Төсвийн орлогын бүтэц, оны эхний 10 сард



Эх сурвалж: Сангийн яам

Зураг 3.26 Төсвийн зардлын бүтэц, оны эхний 10 сард



Эх сурвалж: Сангийн яам

Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өр: Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өрийн ДНБ-д эзлэх хувийн дээд хязгаар 2024 онд 60.0 хувь бөгөөд III улирлын байдлаар ДНБ-ий 44.8²¹ хувь байна.

²¹ 2023 оны II улиралд Засгийн газрын нийт өр (ӨҮЦ) Засгийн газрын өрийн статистик товхимолд зарласнаар

26.9 их наяд төгрөг байгаа нь 2023 оны тодотгосон төсөвт тусгасан ДНБ-д харьцуулахад 44.9 хувь байна.

Хүснэгт 3.3 Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өр болон зээлийн үйлчилгээний төлбөр

	2021	2022	2023*	2023*	2024*
тэрбум төгрөг	Гүй.	Гүй.	Бат.	Тод.	Бат.
Засгийн газрын нийт өр (ӨҮЦ)	21837	27679	35435	39126	39276
ДНБ-д эзлэх хувь	50.1	52.4	65.0	65.0	60.0
Өрийн хязгаар	70.0	70.0	65.0	65.0	60.0
Зээлийн үйлчилгээний төлбөр	828	816	1181	1181	
Төсвийн орлогод эзлэх хувь	6.5	4.7	6.2	6.2	
Төсвийн тэнцэл	-2909	-979	-1426	-1590	-1833
ДНБ-д эзлэх хувь	-4.5	-1.9	-2.6	-2.6	-2.8


Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

4. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН

4.1 Эдийн засгийн гадаад орчны төсөөлөл

Гадаад эрэлт: Дэлхийн эдийн засгийн өсөлтийн 3-р улирлын гүйцэтгэл олон улсын байгууллагуудын төсөөллөөс сайн гарсантай холбоотойгоор 2023 оны глобал өсөлтийн төлөв нэмэгдлээ. Харин БНХАУ-ын өсөлт цаашид саарахаар хүлээгдэж буй нь 2024 оны өсөлтийн төсөөлөл буурахад нөлөөлсөн бол 2025 оны өсөлт өмнөх төсөөллийн адил 3.0 хувьд хэвээр байна.

Зураг 4.1 Улс орнуудын өсөлтийн төсөөлөл



Эх сурвалж: Блүмберг, Рубини, EIU, ОУВС, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагуудын төсөөллийн дундаж

Мөн Израил-Хамасын хооронд өрнөж буй мөргөлдөөн геополитикийн эрсдэлийг улам нэмэгдүүлж, дэлхийн эдийн засгийн

өсөлтийн төсөөллийн тодорхой бус байдлыг үлэмж өсгөлөө. Дараах хэсэгт сонгосон орнуудын төлөвийг дэлгэрүүлж тайлбарлая:

Олон улсын байгууллагууд, шинжээчид **БНХАУ-ын** эдийн засгийн өсөлтийн төсөөллийг **2023 онд 5.2 хувь, 2024, 2025 онуудад 4.4 хувьд** тогтвортой байхаар шинэчлэв. Энэ нь өмнөх улирлын төсөөлөлтэй харьцуулахад 0.1-0.3 нэгж хувиар буурсан төсөөлөл юм. Тус улсын төсөв, мөнгөний тэлэх бодлого үр дүнгээ өгч жижиглэн худалдаа, аж үйлдвэрийн салбарын идэвхжил нэмэгдсэн нь III улиралд эдийн засгийн өсөлт жилийн 4.9 хувьд хүрч, шинжээчдийн хүлээлтээс давахад нөлөөлөв. Гэхдээ тус улсын үл хөдлөх хөрөнгийн аварга компани Country Garden 10-р сарын дундуур гадаад бондын дефолт зарласан, үл хөдлөх салбарын борлуулалт эхний 10 сарын байдлаар жилийн 7.8 хувиар унаад байгаа зэрэг нь цаашид эдийн засгийн өсөлтөд томоохон эрсдэл, тодорхой бус байдлыг бий болгоод байна.

АНУ-ын эдийн засгийн өсөлт 2023 оны III улиралд **4.9** хувьд хүрч, олон улсын байгууллагуудын өмнөх төсөөллөөс 4 дахин өндөр гүйцэтгэлтэй гарав. Ийнхүү улирлын ДНБ-ий жилийн өсөлт сүүлийн 2 жилийн хамгийн өндөр түвшинд хүрсэн нь тус улсын хөдөлмөрийн захын идэвхжилтэй холбоотой хувийн хэрэглээ нэмэгдэж, тэр дундаа үйлчилгээний салбарын өсөлт эрчимжсэнтэй холбоотой байв. Улмаар АНУ-ын 2023-2024 оны эдийн засгийн өсөлтийн төсөөлөл өмнөхөөс нэмэгдэв. Гэхдээ одоогийн хэрэгжүүлж буй мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр дараа жилийн өсөлт энэ оноос саарах төлөв хэвээр байна. Харин 2025 оноос мөнгөний бодлогын төлөв зөөлөрч эдийн засгийн өсөлт нэмэгдэх хүлээлттэй байна.

Евро бүсийн эдийн засгийн өсөлт 2023 оны III улиралд **0.1 хувьд** хүрч хүлээлтээс доогуур байв. Европын төв банк бодлогын хүүгээ эрчтэй өсгөсөн шийдвэрүүдийн нөлөө энэ онд Европын холбооны эдийн засгийн өсөлт, санхүүгийн зах зээлд хүчтэй илэрч, улмаар ийнхүү өсөлт удаашраад байна. Энэхүү бүсийн хамгийн том эдийн засаг болох Германы эдийн засаг III улиралд жилийн 0.4 хувийн бууралттай гарсан нь цаашид Евро бүсийн өсөлтийн төсөөлөл саарахад том жинтэй байв.

ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2023 оны III улиралд 5.5 хувьд хүрч хүлээлтээс сайн гарав. Засгийн газрын их хэмжээний зарцуулалт, хувийн хэрэглээ өсөж байгаа зэрэг нь өсөлтөд эергээр нөлөөлж байна. Шинжээчдийн үзэж буйгаар ОХУ-ын эдийн засаг барууны орнуудын хоригт зохицож, зарим салбарууд хэвийн үеийн түвшинд хүрч байна.

Гадаад инфляц: Дэлхийн ихэнх оронд инфляцын эрч саарсаар байгаа ч төв банкуудын зорилтот түвшинээс өндөр байна. АНУ-ын инфляц 10-р сард 3.2 хувьд хүрч буурав. Үүнийг бүтээгдэхүүний бүрэлдэхүүнээр задлан харвал нефтийн бүтээгдэхүүний үнийн бууралт гол нөлөөг үзүүлжээ.

Евро бүсийн инфляц сүүлийн нэг жилийн хугацаанд дараалан буурч, 10-р сард 2.9 хувьд хүрлээ. Хүнс, архи, тамхины үнийн өсөлт хамгийн өндөр байгаа бол эрчим хүчний үнэ жилийн 11.1 хувиар буурсан байна.

БНХАУ-д энэ оны 10-р сарын байдлаар өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үнэ жилийн 0.2 хувиар буурлаа. Ийнхүү дефляц бий болоход хүнсний үнэ, тэр дундаа гахайн махны үнийн бууралт гол нөлөөг үзүүлсэн байна. Түүнчлэн, суурь инфляц энэ оны турш нам түвшинд буюу 0.5 хувийн орчимд тогтвортой байна.

ОХУ-д инфляц 10-р сард 6.7 хувьд хүрч нэмэгдлээ. Тус улсад рублийн ханш ихээр суларч, дайны төсвийн зардал нэмэгдэж байгаа нь үнийн түвшин нэмэгдэх шалтгаан болж байна.

Гадаад хүү: ХНБ 10-р сарын хурлаар бодлогын хүүг 5.5 хувьд хэвээр хадгалав. Сүүлийн улиралд инфляц хүлээлтээс хурдтай буурсан нь 12 сард болох дараагийн хурлаар ХНБ бодлогын хүүг дахин хэвээр хадгалах хүлээлтийг үүсгээд байна. Европын төв банк 10 дараалсан хүү нэмэгдүүлэх шийдвэрийн дараа 10-р сарын хурлаараа бодлогын хүүг хэвээр хадгалах шийдвэр гаргасан нь сүүлийн саруудад инфляц буурч байгаатай холбоотой. Гэвч ойрын хугацаанд инфляцын түвшин зорилтот 2.0 хувьд хүрч буурахааргүй байна.

4.2. Экспортын үнийн төлөв

БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналтаас үүдэн олон улсын зах зээлд металлын үнэ буурах эрсдэл нэмэгдлээ.

Зэс: Зэсийн үнэ 2023 оны 10-р сард 8052 ам.доллар/тн хүрч оны эхнээс 12.6 хувиар буурлаа. БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн төлөв удаашрах хүлээлт бий болсон нь зэсийн орц ихтэй нүүрс хүчлийн хийн ялгарлыг бууруулах төслүүдийн явцыг удаашруулж, улмаар зэсийн эрэлт буурав. Үүнээс шалтгаалж зэсийн үнэ буураад байна. Харин дараа оны БНХАУ-ын өсөлтийн төсөөлөл багассан нь зэсийн эрэлт бага байх хүлээлтийг үүсгэж байгаагийн зэрэгцээ зэсийн нийлүүлэлт сайн байх таамаглалтай холбоотой байна. 2025 оноос цахилгаан машин, сэргээгдэх эрчим хүч, цахилгаантай холбоотой дэд бүтцийн ажлууд эрчимжсэнээр зэсийн эрэлт нэмэгдэж, үнэ өсөх тооцооллыг олон улсын байгууллагууд боловсруулжээ.

Алт: Алтны үнэ 10-р сарын дунджаар 1984 ам.доллар/унци буюу харьцангуй өндөр түвшинд хадгалагдаж байна. Улс орнуудын инфляц өндөр, геополитикийн хурцадмал байдал ээлж дараалан бий болж байгаа нь алтны эрэлтийг өсгөж, үнэ өндөр байх нөхцлийг бий болгож байна.

Коксжих нүүрс: Коксжих нүүрсний хилийн үнэ 3-р улиралд төсөөллийн орчимд гарав. Энэ онд БНХАУ-д өрнөж буй нүүрсний уурхайнуудын хяналт шалгалтын үйл ажиллагаанаас шалтгаалж тус улсын уурхайнуудын үйл ажиллагаа тасалдаж байгаа нь нүүрсний үнэ харьцангуй тогтвортой байхад нөлөөлж байна. Цаашид уурхайн хяналт шалгалтын ажил дуусаж, БНХАУ-ын импортын нүүрсний эрэлт буурснаар манай улсын экспортын нүүрсний хилийн үнэ буурах хүлээлттэй байна.


Төмрийн хүдэр: Төмрийн хүдрийн үнэ 10-р сарын дунджаар тонн тутамдаа 119 ам.доллар болж оны эхнээс 0.7 хувиар нэмэгджээ. Энэ оны 3-р улиралд БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын борлуулалт сайнгүй байсан ч дуусаагүй барилгыг дуусгах, дэд бүтцийн ажил хийх, ган экспортлох зэрэгт ихээхэн хэмжээний гангийн эрэлт үүсэж, үнэ өндөр түвшинд хадгалагдав. Харин цаашид БНХАУ-ын барилгын салбарын хүндрэлтэй холбоотойгоор гангийн эрэлт саарч, төмрийн хүдрийн үнэ буурах хүлээлт хэвээр байна.

Газрын тос: Brent газрын тосны үнэ 10-р сарын дунджаар 87.4 ам.доллар/баррель байв. Хэдийгээр Сауди Араб, ОХУ тэргүүтэй (ОПЕК+)-ийн орнууд газрын тосны нийлүүлэлтээ хязгаарлаад буй ч (ОПЕК+)-д хамаардаггүй АНУ, Бразил зэрэг орнуудын газрын тосны нийлүүлэлт өндөр байна. Дараа онд ч энэ байдал

үргэлжлэх хүлээлттэй тул нефтийн бүтээгдэхүүний үнийн төсөөлөл өмнөхөөс буурав. Израил-Хамасын мөргөлдөөнөөс шалтгаалж газрын тосны үнэ түр зуур нэмэгдсэн ч эргэн мөргөлдөөнөөс өмнөх үеийн түвшиндээ хүрээд байна. Цаашид тус мөргөлдөөн бүс нутгийн хэмжээнд өрнөхөөс бусад тохиолдолд газрын тосны үнэд нөлөөлөх нөлөөлөл харьцангуй бага байхаар байна.

Худалдааны нөхцөл: Худалдааны нөхцөлийн жилийн өөрчлөлт өмнөх төсөөллийн орчимд хадгалагдлаа (Зураг 4.2). Ирэх онд импортын үнийн өсөлт харьцангуй бага байх бол экспортын үнэ буурч, худалдааны нөхцөл муудах хүлээлт хэвээр байна.

Зураг 4.2 Худалдааны нөхцөл, экспорт, импортын үнийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

4.3. Төлбөрийн тэнцэл

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2023 оны III улиралд 318 сая ам.доллар, оны эхний 9 сард 791 сая ам.долларын ашигтай байна.

Мөн сүүлийн 16 жилийн турш алдагдалтай байсан урсгал данс оны эхний 9 сард 468 сая ам.долларын ашигтай гарлаа²².

Төлбөрийн тэнцэл ийнхүү ашигтай байж, гадаад валютын нөөц нэмэгдэхэд дараах хүчин зүйлс голлон нөлөөлж байна.

- Нүүрсний экспортын биет хэмжээ түүхэн дээд түвшинд хүрч нэмэгдэж буй;
- Дотоодын санхүүгийн нөхцөл чанга байгаатай холбоотойгоор хэрэглээний бүтээгдэхүүний импортын өсөлт оны эхний 3 улиралд саарсан;
- Оюу толгойн хөрөнгө оруулалт болон Засгийн газар, банкуудын гадаад зээлийн ашиглалт санхүүгийн дансны цэвэр орох урсгалыг бүрдүүлж байна.

Зураг 4.3 Төлбөрийн тэнцэл 2023 оны III улиралд 318 сая ам.долларын ашигтай байв



Эх сурвалж: Монголбанк

Төлбөрийн тэнцлийг гол бүрэлдэхүүн хэсгүүдээр дэлгэрүүлж тайлбарлавал:

Экспортын орлого 2023 оны III улиралд өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар өсөв. Чулуун нүүрсний экспортын биет хэмжээ оны эхний 3 улиралд 46.8 сая тоннд хүрч нэмэгдсэн, Оюу толгойн далд уурхайн зэсийн баяжмалын үйлдвэрлэл хүлээлтээс өндөр байгаа нь экспортын орлогын

өсөлтийн голлох хэсгийг бүрдүүлэв. Түүнчлэн, мах, махан бүтээгдэхүүний экспорт энэ онд сэргэж²³, нийт экспортын орлогын 1.6 нэгж хувийн өсөлтийг бий болголоо (Хүснэгт 4.1).

Хүснэгт 4.1 Экспортын жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр

сая ам.доллар	2022 III	2023 III	Жилийн өсөлт %	Өсөлтөд эзлэх %
Нийт экспорт	3,611	3,732	3.3	3.3
Чулуун нүүрс	2,156	2,087	-3.2	-1.9
Боловсруулаагүй нефть	129	96	-25.6	-0.9
Мах, махан бүтээгдэхүүн	8	66		1.6
Бусад самар	-	4		0.1
Жонш, лейцит, нефелинг	23	68		1.2
Мөнгөний хүдэр, баяжмал	45	28	-37.6	-0.5
Молебдиний хүдэр, баяжмал	21	20	-2.4	0.0
Төмрийн хүдэр, баяжмал	118	94	-19.7	-0.6
Мөнгөжөөгүй алт	235	223	-5.1	-0.3
Ноолуур	112	154	37.8	1.2
Цайрын хүдэр, баяжмал	69	27	-60.0	-1.1
Зэсийн хүдэр, баяжмал	585	670	14.6	2.4
Бусад	113	194	72.3	2.3

Эх сурвалж: ГЕГ

Импортын жилийн өсөлт энэ оны III улиралд 3.1 хувь буюу өмнөх улирлын орчимд байна. Энэхүү өсөлтийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, шатахуун болон суудлын автомашины импортын өсөлт бүрдүүлжээ. Нүүрсний экспортын сэргэлттэй уялдан эдийн засгийн идэвхжил өндөр байгаагаас шалтгаалан шатахуун болон хөрөнгө оруулалтын шинжтэй барааны импортын эрэлт нэмэгдэж байна (Хүснэгт 4.2).

Хүснэгт 4.2 Импортын жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр

сая ам.доллар	2022 III	2023 III	Жилийн өсөлт %	Өсөлтөд эзлэх %
Нийт импорт	2,408	2,482	3.1	3.1
Хэрэглээний бүтээгдэхүүн	720	677	-5.9	-1.8
Түргэн эдэлгээт	396	330	-16.6	-2.7
Удаан эдэлгээт	324	347	7.2	1.0
Суудлын автомашин	198	218	10.3	0.8
Хөрөнгө оруулалтын бүт.н	988	1084	9.7	4.0
Нефтийн бүтээгдэхүүн	462	488	5.6	1.1
Дизель	277	279	0.7	0.1
Бусад шатахуун	186	210	12.8	1.0
Аж үйлдвэрлэлийн орц	233	228	-1.9	-0.2
Бусад	5.0	4.2	-16.4	0.0

Эх сурвалж: ГЕГ, Монголбанк


²² Төлбөрийн тэнцлийн дэлгэрэнгүй статистикийг stat.mongolbank.mn хаягт хандан авах боломжтой.

²³ Өмнөх жилийн эхний хагаст гол худалдан авагч буюу БНХАУ манайхаас мах экспортоор авахыг түр зогсоож байв.

Харин өмнөх 2 жилд өсөлт нь дунджаар 30 хувийг даваад байсан хэрэглээний бүтээгдэхүүний импортын өсөлт энэ онд саарч байна. Үүнд, суудлын автомашин, гэр ахуйн тавилга, цахилгаан хэрэгслээс бусад импорт буурсан нь нөлөөлөв. Гэхдээ төсвийн зардал 2023 оны сүүлийн хагасаас эрчтэй нэмэгдэж байгаа нь импортын өсөлтийг эрчимжүүлж болзошгүй байна.

Үйлчилгээний дансны алдагдал тайлант улиралд өмнөх оны мөн үеэс 140 сая ам.доллаароор буурч, 529 сая ам.долларт хүрлээ (Зураг 4.). Дотоодод ирэх жуулчдын тоо энэ онд эрчтэй нэмэгдэж байгаа нь үйлчилгээний зориулалттай валютын орох урсгал сайжрахад голлон нөлөөлж байна. Түүнчлэн төмөр замын дамжин өнгөрөх тээврийн орлого өндөр хэвээр байгаа нь үйлчилгээний дансны алдагдлыг бууруулж байна.


Зураг 4.4 Үйлчилгээний данс



Эх сурвалж: Монголбанк

Орлогын дансны алдагдал III улиралд 503 сая ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 22 сая ам.доллаароор бага байв (Зураг 4.). Үүнд дотоодын аж ахуйн нэгжүүд болон Хөгжлийн банкны гадаад зээлийн хүүний төлбөр өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан нь нөлөөлжээ.


Зураг 4.5 Орлогын дансны алдагдал



Эх сурвалж: Монголбанк

Санхүүгийн дансны тэнцэл 2023 оны III улиралд 246 сая ам.долларын ашигтай байв. Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилт санхүүгийн дансны орох урсгалыг голлон бүрдүүлсэн хэвээр байна.

Зураг 4.6 Санхүүгийн данс 246 гаруй сая ам.долларын ашигтай байв.



Эх сурвалж: Монголбанк

